



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Г Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах
тухай Г

Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх заалт, Монгол улсын ШУА-ийн дүрмийн 22 дугаар зүйлийн “л” дэх хэсэг, 30 дугаар зүйл, Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцээд ТОГТООХ нь:

1. ШУА-ийн Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн хурлын 02 тоот тогтоолоор баталсан “ШУА-ийн харьяа хүрээлэнгийн захирлыг сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх журам”-ын дараах заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1.1. Энэхүү журмын зорилго нь Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Шинжлэх ухааны Академийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, Монгол Улсын Шинжлэх ухааны Академийн дүрмийн 29, 30 дугаар зүйлийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ыг баримтлан хэрэгжүүлж, ШУА-ийн харьяа хүрээлэнгийн захирлын сул орон тоог нөхөх шалгалт зохион байгуулах, захирлын албан тушаалд тавигдах шаардлагыг хамгийн сайн хангасан эрдэмтнийг чадахуйн зарчимд үндэслэн сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх харилцааг зохицуулна.

2.4.2. Нэр дэвшигч захирлын албан тушаалын тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж буй байдлыг үнэлнэ.

2.4.3. Захирлын албан тушаалд хамаарах хууль, эрх зүй, бодлогын баримт бичгийн талаарх мэдлэг, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх чадвар, монгол хэлний ярианы болон бичгийн чадварын шалгалтын захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж шалгалт авах ажлыг зохион байгуулна.

2.4.4. Нэр дэвшигчийн удирдан зохион байгуулах, манлайлах болон багаар ажиллах чадварын шалгалтыг захирлыг сонгон шалгаруулах комисс ярилцлагаар авна.

2.4.6. Журмын 2.4.3, 2.4.4, 2.4.5-д заасан шалгалтыг “Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-ын 9 дүгээр зүйлийн 9.12 дахь заалтад заасан оноогоор үнэлж, нийт авбал зохих 100 онооноос 60 ба түүнээс дээш оноо авсан нэр дэвшигчийг сонгон шалгаруулалтын эхний шатанд тэнцсэнд тооцно.

2. Мөн журамд доор дурьдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй.

2.4.5. Нэр дэвшигчийн төсөв, санхүү, хүний нөөц, гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх чадварын шалгалтыг сорилоор эсвэл албан бичиг, шийдвэрийн төсөл боловсруулах хэлбэрээр, ярилцлагаар гэсэн аргуудын аль нэгийг сонгон захирлыг сонгон шалгаруулах комисс авна.

3. Журмын 2.4.5, 2.4.6, 2.4.7, 2.4.8 гэсэн дугаарыг 2.4.6, 2.4.7, 2.4.8, 2.4.9 гэж өөрчилсүгэй.

4. Журмын 1.4 дэх заалтын "нийтлэг" гэснийг хассугай.

5. Энэхүү тогтоолыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг Тэргүүлэгчдийн газрын дарга (А.Баярбаатар)-д даалгасугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ

ЭРДЭМТЭН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА, АКАДЕМИЧ



Д.РЭГДЭЛ

Б.АВИД